



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 23 өдөр

Дугаар А/566

Есөнбулаг сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Дайчилгааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2 дахь заалт, Засгийн газрын 2025 оны мн/14 дүгээр тогтоолын 2 дахь заалт, аймгийн Улсын дайчилгааны төлөвлөгөөг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдын Улсын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)  
Гишүүдэд: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга)

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дайчилгааны офицер)

(Тагнуулын ерөнхий газрын Говь-Алтай аймаг дахь хэлтсийн мэдээллийн аюулгүй байдлын ажилтан)

(Статистикийн хэлтсийн дарга)

(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

(Эрүүл мэндийн газрын дарга)

(Авто тээврийн төвийн дарга)

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга)

(Боловсролын газрын дарга)

(Сумын Засаг дарга нар)

Нарийн бичгийн дарга: (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төсвийн зарлага хариуцсан мэргэжилтэн)

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ



